

**“Фронттиер Лэнд Групп” ХК-ийн
Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлын ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Фронттиер Лэнд Групп ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг 2018 оны 04 сарын 30-нд Улаанбаатар хотод зарлан хуралдуулав. Хурал Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт орших Пума Имperiал Зочид Буудлын 2 дугаар давхрын хурлын бага зааланд 15 цаг 04 минутад эхлэв.

Хурлын ирц 84,36%-тай бүрдсэн болохыг Хурлын Тооллогын Комиссын Дарга Б.Мягмар танилцуулав.

Хурлын ирц бүрдсэн тул Хурлын дарга М.Төвшин хурлыг нээн, компанийн ХЭЭХ-ын дэг ба хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулан, хуралд оролцогсод асуудлуудаа хэлэлцэж явж байгаад санал асуулгаа авахаар тохиров.

Хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
2. Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг батлах
3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, нэмэлт хувьцаа гаргах асуудлыг хэлэлцэж батлах
4. Компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах болон шаардах эрх хэрэгжүүлэх тухай хэлэлцэх
5. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилсэн найруулгыг батлах
6. Ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсэн тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
7. Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг батлах
8. Бусад

“Фронттиер Лэнд Групп” ХК -ийн Гүйцэтгэх Захирал Мэндийн Төвшин Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг 2018 оны бизнес төлөвлөгөөтэй хамт танилцуулав. Тэрээр компанийн ерөнхий танилцуулга болон үйл ажиллагааны өнөөгийн байдлыг танилцуулахдаа:

“Фронттиер Лэнд Групп” ХК нь анх “Туул Сонгино Усны Нөөц” ХК нэртэйгээр Техникийн Усны Байгууламж, Ундны Усны Байгууламж, Усан Цэнэгт Цахилгаан Станц гэсэн гурван төслийг хэрэгжүүлэхээр 2006 оны 12-р сарын 30-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Тус компани нь эхний төсөл болох Техникийн Ус Боловсруулах байгууламжийг барих зорилгоор Монголын Хөрөнгийн Биржид хувьцаагаа 2007 оны 12 дугаар сард анх гаргасан бөгөөд нийт 13 200 061 250 төгрөгийн хөрөнгийг босгосон байна. 2010 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хуралдсан Хувьцаа Эзэмшигчдийн Элжит Хурлаар дэд бүтцийн эдгээр гурван төслийг эдийн засгийн үр ашиг багатай гэж тооцсоны үндсэн дээр үйл ажиллагаагаа өөрчлөх шийдвэр гарсан. Төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон гол шалтгаан нь Компани төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, патент, засгийн газрын агентлагуудтай байгуулсан гэрээ зэрэг биет бус хөрөнгүүдийг эзэмшдэггүй байсантай холбоотой. Тус хурлаар компанийн нэрийг “Монголиа Девелопмент Ресорсес” ХК болгон өөрчилж, компани үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

2017 онд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооноос санал болгосны дагуу 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Сүлд Аудит компаниар аудит хийлгэсэн. Аудитын дүгнэлтээр компанийн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байна гэсэн санал дүгнэлт гарсан.

Нийт хөрөнгө буюу тэнцэл нь жилийн эхэнд байсан нийт хөрөнгө 16644.3 сая төгрөгөөс 2017 оны жилийн эцсийн байдлаар 14808,4 сая төгрөг болсон байна. Үүнд 2017 оны жилийн эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгө 10,8% хувийг, эргэлтийн бус хөрөнгө 89,2% хувийг эзэлж байгаа нь хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд бүртгэж хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж 1,3 тэрбум төгрөгөөр оффис болон үйлчилгээний зориулалттай хөрөнгийг бууруулан бүртгэж, санхүүгийн хувьд тогтвортой үйл ажиллагаа явагдсан. Эргэлтийн хөрөнгө болон үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгөө, удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу борлуулж хөрөнгө оруулалтанд оруулж хөрөнгө худалдаж авах, бусад үйл ажиллагааг санхүүжүүлэн төлбөрийн чадварын хувьд бүрэн боломжтой байна гэсэн дүгнэлт гарсан.

Үйл ажиллагааны орлогын тухайд 2017 оны жилийн эцсийн байдлаар 606,5 сая төгрөг байна.

Үйл ажиллагааны зардлын тухайд 2017 онд 119,4 сая төгрөгийг үйл ажиллагаа явуулсан өртөгт, 739,0 сая төгрөгийг үйл ажиллагаа явуулсан улирдлагын зардалд, 185,2 сая төгрөгийг үл хөдлөх хөрөнгө борлуулсаны олз гарз, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны зөрүү бууралт зэргээс шалтгаал гарсан. 2017 оны жилийн эцсийн удирдлагын зардалд тодорхой хэмжээгээр нөлөөлөл үзүүлсэн томоохон хэмжээний зардлууд нь оффис зориулалттай үл хөдлөх хөрөнгийг элэгдүүлж эхэлсэнтэй холбоотойгоор хэвийн хэмжээний элэгдлийн зардал 18,9 хувь /140,4 сая төгрөг/, үйлчилгээний зардал, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зээлийн хүүгийн зардал 22,7 Хувь /167,8 сая төгрөг/-р, бусад зардал, цалин, газрын болон үл хөдлөх хөрөнгийн татварыг тооцож төлсөн 430,8 сая

төгрөг байгаа зэрэг зохих хэмжээгээр нэмэгдсэн нь манай байгууллагын хувьд үйл ажиллагаагаа хэвийн явуулах, цаашид олох орлогоо нэмэгдүүлэх, байр худалдах зорилгоор өөрийн эзэмшлийн хөрөнгүүдийг сайжруулахад, засвар үйлчилгээ хийлгэх, зах зээл дээр хөрөнгийн түрээс болон үнийн уналттай холбоотойгоор тодорхой хэмжээгээр орлого болон зардлаа хэвийн хэмжээнд байлгах талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан.

Компани нь Монгол улсын татварын хууль тогтоомж, заавар журмын дагуу хугацаанд нь татварын тайлангаа гаргаж өгдөг. ТУЗ-ын зүгээс тус компанийн гүйцэтгэх удирдлага дэлхийн болон Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа хэдий ч, хүчин чармайлт гаргаж сайн ажилласан гэж дүгнэсэн.

Гүйцэтгэх захирал М.Төвшин дараагийн хэлэлцэх асуудал болох Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг танилцуулахдаа, Үл хөдлөх хөрөнгийн салбарт хөрөнгө оруулалт хийхээс гадна монгол болон шинэ тутам хөгжиж буй зах зээл рүү нэвтрэхээр зорьж байгааг илэрхийлэв. Харьцангуй хязгаарлагдмал Монголын зах зээлд үйл ажиллагаа явуулах нь учир дутагдалтай байгаа тул хаана ямар боломж байгааг соргоогоор олж хараад, тэнд хөрөнгө оруулж, ашиг хүртэх боломжтой байна гэдгийг тайлбарлав. Энэ зорилгоор 10 тэрбум хүртэл төгрөгийн нэмж хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх талаар хуралдааны үеэр мэдээлж ярилцав. Монгол болон хөгжиж буй шинэ тулгар зах зээлтэй улсуудын үл хөдлөх хөрөнгийн салбарт дараах цогц бүтээгдэхүүн, үйлчилгээний багцуудыг санал болгож ажиллахаар төлөвлөж байгааг илэрхийлэв. Үүнд: i) Орон сууцны болон оффисын барилга, төслийн хөрөнгө оруулалт, бүтээн босголт ii) Үл хөдлөх хөрөнгийн зөвлөх үйлчилгээ iii) Үл хөдлөх хөрөнгийн зуучлал iv) Үл хөдлөх хөрөнгийн менежмент v) Үл хөдлөх хөрөнгийн түрээс үйлчилгээнүүд багтах юм.

Гүйцэтгэх захирал М.Төвшин үргэлжлүүлэн 3, 4 –р асуудал болох компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх асуудлыг хэлэлцэх, хувьцааг хуваах эсвэл нэрлэсэн үнийг буулгах, компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах болон хувьцааг эргүүлэн компанид худалдах шаардах эрх хэрэгжүүлэх тухай танилцуулав. Нийт 10 тэрбум төгрөгийн нэмэлт хувьцаа босгох бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороотой энэ талаар ярилцсан. Компанийн хувьцаа анх 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй гаргаж байсан бол одоогоор манай хувьцааны ханш 300 төг орчим байна. Тиймээс нэрлэсэн үнээс доогуур худалдаж болохгүй байна. Компанийн тухай хуулийн 31.2-т хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх арга замуудыг дурдсан байдаг. Шинээр 1000 төг-өөр хувьцаа гаргахад зах зээл дээр 300 төг-өөр худалдаалагдаж байгаа тул худалдан авах хүн олдохгүй. Тиймээс нэрлэсэн үнээ буулгах арга байна. Санхүүгийн Зохицуулах Хороо нэрлэсэн үнээ буулгахыг зөвшөөрсөн. Энэ нь хөрөнгө оруулагч / хувьцаа эзэмшигчдэд ямар нэгэн хохиролгүй юм. Хуулийн дагуу нэрлэсэн үнийг нэмж, бууруулж болно. Ингэснээр НББ-ийн хувьд л өөрчлөлт (бичилт) орох юм. “Нэмж төлсөн капитал” дансанд бүртгэгдэнэ

хэмээн тайлбарлаад нэмэлт хувьцаа гаргах асуудлыг хариуцан ажиллаж буй андеррайтерын компанийн захирал Г.Оюунболдыг энэ талаар дэлгэрүүлж ярихыг хүсэв.

“Евразиа Капитал Холдинг” андеррайтерийн компанийн захирал Г.Оюунболд:

Би Фронттиер Лэнд Групп компанид андеррайтерийн үйлчилгээ үзүүлж байгаа компанийн захирал. Мөн энэ компанийн томоохон хувьцаа эзэмшигчдийн нэг. Одоо бирж дээр 300 төгрөг байгаа хувьцааг 1000 төгрөгөөр гаргахад худалдан авах хүн олдохгүй. Тиймээс хувьцааны нэрлэсэн үнээ бууруулах эвсэл хуваах арга бидэнд байна. Фронттиер Лэнд Групп 10 тэрбум хүртэл төгрөгийн нэмэлт хувьцаа гаргахыг бид зөв гэж бодож байна. Бид өнгөрсөн жил хөрөнгө оруулагч татах гэж хичээж ажилласан. Манай компани энэ компанид хөрөнгө оруулсан учраас компанийн үйл ажиллагаа сайн байвал бидэнд ашигтай. Бид алдагдалгүй байхыг хүсэж байна.

Гэхдээ бид хөрөнгө оруулалт босгож чадна.

Гүйцэтгэх захирал М.Төвшин үргэлжлүүлэн 5, 6-р хэлэлцэх асуудлын талаар танилцуулав. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрээс хамаарах тухай мэдэгдэв. Компанийн үйл ажиллагааны чиглэл одоо гадаад худалдаа гэж явж байгаа бөгөөд үүнийг нарийвчилж үл хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийн худалдаа, түрээс, зуучлал, үл хөдлөх хөрөнгийн менежмент гэх зэрэг үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаануудыг нэмж оруулах саналтай байна.

Ногдол ашиг тараахгүй байх шийдвэрийг Гүйцэтгэх захирал М.Төвшин үргэлжлүүлэн танилцуулав. Бид 2017 онд 1,73 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй гэж ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Үргэлжлүүлэн сүүлийн хэлэлцэх асуудал болох компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийн талаар Гүйцэтгэх захирал М.Төвшин танилцуулав.

Компанийн үүсгэн байгуулагч нар нийт 4,588,876,575 төгрөгийг төслүүдийн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх, газар, тоног төхөөрөмж худалдан авах, Техникийн Усны Байгууламжийн зураг төслийн ажил хийлгэх болон бас бус төсөлтэй холбоотой ажлуудад зарцуулсан байдаг. 2009 онд нийт хувьцааны 70% гаруй хувийг эзэмшдэг олон улсын хөрөнгө оруулагчид төслийн хэрэгжилт, тэдгээрийн хэтийн төлөвт магадлан шинжилгээ хийлгэхээр санаачилж, төслийг эдийн засгийн үр ашиггүй гэж үзэн зогсоосон. Төслийг хэрэгжүүлэх боломжгүй гол шалтгаан нь Компани төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, патент, засгийн газрын агентлагуудтай байгуулсан гэрээ зэрэг биет бус хөрөнгүүдийг эзэмшдэггүй байсан юм. Үүсгэн байгуулагчид биет бус хөрөнгөөр компанид хөрөнгө оруулалт хийхгүй байхаар шийдэж, харин тэдгээрийг ашиглан төслүүдээ компаниас хараат бусаар хэрэгжүүлэхээр шийдсэн. Мөн үүсгэн байгуулагчид компанид хөрөнгө оруулалт хийх үүргээсээ чөлөөлөгдөхийг хүссэн. Тиймээс Компани үүсгэн байгуулагчидтай гэрээ байгуулсан ба уг гэрээ ёсоор үүсгэн байгуулагчид үүргээсээ

чөлөөлөгдөж энэ дагуу мөн тэдний компанид хувьцаа эзэмших эрх цуцлагдсан. Гэрээ ёсоор эдгээр хөрөнгийг компанийн санхүүгийн тайланд тусгасан бөгөөд, үүсгэн байгуулагчид төсөлдөө хөрөнгө оруулагч олж, компанид 4 588 876 575 төгрөгөө нөхөн төлөхөөс наана хөрөнгийг үүсгэн байгуулагчдад шилжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн.

Та бүхэнд дуулгах сайхан мэдээ байна. Учир нь компанийн үүсгэн байгуулагч нар Засгийн газартай Концессын гэрээ байгуулсан. Иймээс бид санхүүжилтийн гэрээ нааштайгаар шийдэгдэх байх гэж харж байна. Ингээд хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцууллаа. Та бүхэнд санал хүсэлт, асуух зүйл байвал асууна уу!

Ийнхүү хурлаар хэлэлцэх бүх асуудлуудыг хэлэлцэж нэмэлт тодруулга хийсний дараа хурлын дэгийн дагуу Тооллогын комиссын дарга саналын хуудас бөглөх зааварчилгаа, тооллогын журмыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулаад Хурал зохион байгуулах бүрэлдэхүүн хуралд биеэр болон итгэмжлэлтэй ирсэн хувьцаа эзэмшигчдээс холбогдох журмын дагуу саналын хуудсыг хураан авч тоолов.

Саналын хуудаснуудыг нягтлан шалгаж, тооллогын нэгтгэсэн дүнг Тооллогын Комиссын дарга Б.Мягмар хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

Санал хураалтад Компанийн нийт гаргасан 13,750,000 хувьцаанаас халаасны хувьцааг хассан саналын эрх бүхий нийт 13,744,342 хувьцаанаас 11 594 828 ширхэг хувьцаа буюу 84,36 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцэх 8 асуудлаар өгсөн саналын үр дүн дараах байдлаар гарсныг Б.Мягмар мэдэгдэв:

	Хэлэлцсэн асуудлууд	Зөвшөөрсөн саналын тоо	Хувь
1.	Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	11 594 828	100%
2.	Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг батлах	11 594 828	100%
3.	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, нэмэлт хувьцаа гаргах асуудлыг хэлэлцэж батлах	11 594 828	100%
4.	Компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах болон шаардах эрх хэрэгжүүлэх тухай хэлэлцэх	11 594 828	100%
5.	Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилсэн найруулгыг батлах	11 594 828	100%
6.	Ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсэн тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах	11 594 828	100%
7.	Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг батлах	11 594 828	100%
8.	Бусад	9 772 375	84.28%

Хурлын дарга хурал амжилттай болсныг зарлаж хурлыг хаан үг хэлээд, хуралтай холбоотой бүх бичиг баримтыг зохих журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо,

Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх болохыг мэдэгдэн хурлыг албан ёсоор 15 цаг 58 минутад хаав.

ХЯНАСАН:

М.ТӨВШИН /ХУРЛЫН ДАРГА/

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Г. САНЖААСҮРЭН /ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА/

